УЛСЫН ДРАМЫН ЭРДМИЙН ТЕАТРЫН ЗАХИРГАА,
ТЕАТРЫН ДЭРГЭДЭХ ҮЙЛДВЭРЧНИЙ ЭВЛЭЛИЙН ХОРООНЫ
2026-2028 ОНЫ ХАМТЫН ГЭРЭЭ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Энэхүү Хамтын гэрээг Монгол улмын нэгдэн орсон Олон улсын гэрээ конвенц, Хөдөлмөрийн тухай хууль, Үйлдвэрчний эвлэлүүдийн эрхийн тухай хуулийг тус тус үндэслэн Ажил олгогчийг төлөөлж Улсын драмын эрдмийн театрын захирал (**Н.Наранбаатар**), ажилтныг төлөөлж театрын дэргэдэх Үйлдвэрчний эвлэлийн хороо-ны дарга (**Г.Амгаланбаатар)** нар хөдөлмөрийн харилцааг зохицуулах, үйл ажиллагааг хэвийн явуулах, ажилчдын ажиллах орчин нөхцөлийг сайжруулах, орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх, тэдэнд нийгмийн халамж үйлчилгээг хүртээх, улмаар нийгмийн баталгааг хангах зорилгоор энэхүү Хамтын гэрээг байгуулав.

1.2 Хамтын гэрээ нь ажилтны хөдөлмөрлөх эрх, түүнтэй холбогдсон хууль ёсны ашиг сонирхлыг хуулиар тогтоосон баталгаанаас илүү нөхцөлөөр хангах, хуулиар шууд зохицуулагдаагүй бусад асуудлыг зохицуулах хууль эрх зүйн бичиг баримт юм.

1.3 Хамтын гэрээний заалтуудаас илүү нөхцөлөөр байгуулагдсан хөдөлмөрийн гэрээний заалтууд шууд мөрдөгдөнө.

1.4 Талууд гэрээнд заасан

1.5 Үйлдвэрчний эвлэл нь хүчин төгөлдөр үйлчилж буй аливаа хууль, журмын дагуу үйл ажиллагаагаа явуулахыг Ажил олгогч зөвшөөрнө.

Хоёр. Ажил эрхлэлт, ажлын байрны баталгааны талаар

2.1 Ажил олгогч нь уран бүтээлийн үйлдвэрлэл, үйлчилгээг тасралтгүй хэвийн явуулах нөхцөлийг бүрдүүлж, ажилтныг ажлын таатай нөхцөлөөр хангана.

2.2 Театрын үйл ажиллагааны батлагдсан төсвийн санхүүжилтээс гадна үйл ажиллагааны орлогоос холбогдох хууль эрх зүйн актад үндэслэн тодорхой хөрөнгө төлөвлөж, ажилтны нийгмийн асуудалд зарцуулахын зэрэгцээ театрыг хөгжүүлэх бодлого, чиглэлийг тодорхойлж хэрэгжилтийг ажилтанд тухай бүрд мэдээлнэ.

2.3 Иргэнийг ажилд авах, чөлөөлөх болон сахилгын шийтгэл ногдуулахдаа Хөдөлмөрийн тухай хууль, байгууллагын Хөдөлмөрийн дотоод журмыг мөрдлөг болгон ажиллах бөгөөд Төрийн байгууллагын үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалд судлагдан шинээр ажилд орж буй ажилтныг Танилцуулах хуудсаар, ажил олгогч, ажилтны санаачилгаар хөдөлмөрийн гэрээ дуусгавар болгох, цуцлагдаж буй ажилтны ажил, үүргийг Ажил хүлээлцэх актаар, хөдөлмөрийн харилцаа дуусгавар болж буй тохиолдолд Тооцооны хуудсыг

ашиглан харъяалах нэгжийн албан тушаалтнуудад танилцуулж, гарын үсэг зуруулснаар хуулийн этгээд, иргэнийг хохироолгүйгээр асуудлыг шийдвэрлэнэ.

2.4 Ажилтны хөдөлмөрлөх эрх болон түүнтэй холбогдсон асуудлыг хэлэлцэхдээ шаардлагатай тохиолдолд тухайн ажилтныг биечлэн байлцуулах ба түүний Хөдөлмөрийн гэрээний хугацааг дуусгавар болгох, үргэлжлүүлэх тухай мэдээллийг ажилтанд мэдэгдэнэ. Хэрэв хөдөлмөрийн сахилга бат алдсан, шалтгаангүйгээр ажил тасалсан, хийдүүлсэн, байгууллагын үндсэн үйл ажиллагаанд хохирол учруулсан нь тогтоогдсон ажилтны Ажил олгогчтой байгуулсан хөдөлмөрийн гэрээг дуусгавар болох асуудлыг хэлэлцэх үед уг ажилтныг заавал биечлэн байлцуулах шаардлагагүй.

Гурав. Цалин хөлсний талаар

3.1 Засгийн газрын тогтоолоор төрийн албан хаагчдын сарын үндсэн цалин нэмэгдсэн тохиолдолд (*тарифт*) цалингийн хэмжээ, ажилласан хугацааг харгалзан тооцоолон тогтоож тогтмол хугацаанд олгоно. Засгийн газрын Тогтоол, шийдвэрээр төрийн албан хаагчдын цалингийн сүлжээгээр сарын үндсэн цалин нэмэгдвэл түүнийг баримтлан ажиллана.

3.2 Ажил олгогч байгууллагын дүрэм, Хөдөлмөрийн дотоод журам, зохион байгуулалтын бүтэц, орон тоонд тухайн үеийн ажлын шаардлагаар бий болох зарим албан тушаал, албан тушаалын нэршлийг өөрчлөх, батлагдан орон тоондоо багтаан ажлын шаардлагаар хооронд нь шилжүүлэх, цалин хөлсийг дүйцүүлэх, ажил, албан тушаалын жагсаалт батлахад санал оруулах, оролцох, албан тушаалын тодорхойлолт, хөдөлмөрийн норм, норматив, үндсэн цалингийн сүлжээ, жишиг болон нэмэгдэл хөлс, нэмэгдлийн хэмжээ, шагнал урамшуулал, түүнийг олгох журмыг ҮЭХ-той зөвшилцөн баталж мөрдөнө.

3.3 Хөдөлмөрийн тухай хуулийн 145 дугаар зүйл, Ахмад настны тухай 9 дүгээр зүйлийг хэрэгжүүлэн мэргэжлийн ур чадвар, дадлага туршлагатай ахмад настныг Гэрээт ажилтны гэрээгээр театрын тайзнаа тоглогдох шинэ болон сэргээсэн уран бүтээлд ажиллуулж болно.

3.4 Ажилтан үндсэн ажлынхаа зэрэгцээ ажил, албан тушаал хавсран ажилласан буюу мэргэжил хослон ажилласан бол 40 хүртэлх хувиар, эзгүй байгаа ажилтны үүргийг орлон гүйцэтгэсэн бол 40 хүртэлх хувиар, албан тушаалын тодорхойлолтонд заагаагүй ажил үүрэг гүйцэтгэсэн ажилтанд ажлын үр дүнг харгалзан урамшууллын хэлбэрээр тооцон нэмэгдэл хөлс олгоно. Мөн онцгой тохиолдолд дублёр ролийг амжилттай гүйцэтгэсэн уран бүтээлчдэд үндсэн цалингийн 30 хүртэл хувиар, байгууллагын жилийн ажлын төлөвлөгөөний хэрэгжилтийг шууд удирдан гүйцэтгэсэн нэгжийн болон гүцэтгэх, удирдах албан тушаалтнуудад үндсэн цалингийн 30 хүртэл хувиар, хариуцлагын нэмэгдэл, урамшууллыг тухайн сар, улирал, жилд нь багтаан олгоно.

3.5 Ажилтныг ердийн ажлын өдөр илүү цагаар болон амралтын өдөр ажиллуулаад нөхөж амруулаагүй тохиолдолд 1,5 хувиар бодож нэмэгдэл хөлс олгоно. Баяр

ёслолын үеэр ажилласан тохиолдолд 2 дахин нэмэгдүүлж олгоно. Дээрх тохиолдолд хэлтэс, албын даргын тодорхойлолтыг үндэслэнэ.

3.6 Ажилтны ажлын чанар, үр дүнтэй шууд холбогдож дараах шагналуудыг доорх хувь хэмжээгээр бодож олгоно.

3.6.1 **Эх зохиогч нарын ажлын хөлсийг Захирлын 2026 оны 04 сарын 15-ны өдрийн А/21 тоот** тушаалын дагуу зохицуулж, олгоно.

3.6.2 Үндсэн үйл ажиллагааны орлогын үр дүнгээр Захирлын тушаалаар холбогдох хууль, тогтоомж, тогтоолыг үндэслэн, улирал тутам нэмэгдэлт цалин олгож болно.

3.6.3 Уран бүтээлийн эх зохиогчдын шагналыг олгохдоо тусгайлсан гэрээний дагуу олгоно.

3.6.4 Жилийн турш гүйцэтгэсэн ажлыг үнэлэн, Хөдөлмөрийн гэрээгээр хүлээсэн үүргээ хамт олноо манлайан үр бүтээмжтэй ажилласан ажилтанг Байгууллагын хөдөлмөрийн аваргыг шалгаруулан, сарын үндсэн цалинг 2 хүртэлх сараар.

3.7 Хөдөлмөрийн хөлс олгохтой холбогдсон дүрэм, журам тэдгээрт оруулсан нэмэлт, өөрчлөлтийг ажилтан бүр танилцах боломжтойгоор хувилж тараах болон цахим хаягаар нь ажилтанд илгээнэ.

3.8 Ажилтны цалинг сар бүрийн 10, 25-ны өдрүүдэд тогтмол банкны дансаар болон картаар олгоно. Төсвийн санхүүжилтийг цаг хугацаанд нь хийлгэх талаар санхүүгийн ажилтнууд анхаарч ажиллана.

Дөрөв. Ажил, амралтын цагийн горимын талаар

4.1 Ажилтан, уран бүтээлчдийн 5 хоногийн ажлын цаг 40 байна.

4.2 Ердийн ажлын цагийн үргэлжлэл 8 цаг байна.

4.3 Үдийн хоолны завсарлага 1 цаг байна.

4.4 Ажил олгогч нь ажил үйлчилгээний онцлогыг харгалзан ҮЭХ-ны зөвшөөрөлтэйгээр ажлын цагийн уян хатан графикийг тогтоон мөрдүүлж ажиллах ба тоглолт, сургуулилалт, үйлдвэрлэлийн хуваарийг жил, улирал, сараар төлөвлөн урьдчилан ажилтанд танилцуулсан байна.

4.5 Илүү цагаар болон 7 хоногийн амралт, баяр ёслолын өдрүүдэд ажилтныг ажиллуулахдаа ҮЭХ-нд мэдэгдсэн байна.

4.6 Шаардлагатай тохиолдолд ажилтнуудын илүү цагаар болон уртасгасан цагаар ажиллах ачааллыг зохицуулах зорилгоор ажил олгогч ҮЭХ-той зөвшилцөн илүү цагаар ажиллах графикийг гарган мөрдүүлнэ. Үүнд гадны захиалгатай гэрээт уран бүтээл хийгдэх үеийн ажлын хуваарь болон түүнтэй холбогдсон бусад асуудлууд хамаарахгүй болно. Энэ тохиолдолд урьдчилан хоол, унааны асуудлыг харилцан ярилцаж шийдвэрлэсэн байна.

4.7 Ажил олгогч ажилтанд Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу чөлөө олгож болно. Дараах тохиолдолд цалинтай чөлөө олгоно. Үүнд:

4.7.1 Ажилтан хуримаа хийвэл ажлын 3 хоног,

4.7.2 Хүүхэд нь хуримаа хийвэл ажлын 3 хоног,

4.7.3 Төрсөн ээж, аав, эхнэр, нөхөр, үр хүүхэд нь хагалгаанд орсон, хүнд өвчтөн сахиж, асарсан тохиолдолд 3 хоног,

4.7.4 Өөрийн төрсөн эцэг, эх, ах дүү, гэр бүлийн хүн (эхнэр, нөхөр) нас барсан бол хотод 5 хоног, орог нутагт 10 хоног,

4.7.5 Ажилтны 0-16 насны төрсөн хүүхэд нь өвдөж, сахиж асарсан тохиолдолд ажлын 3-10 хоногийн цалинтай чөлөөг Эмнэлгийн энгийн магадлагааг үндэслэн тус тус олгоно.

4.8 Ажилтны ээлжийн амралтыг уран бүтээлийн жилийн ажлын төлөвлөгөө, үзвэрийн бодлогыг харгалзах ба боломжтой тохиолдолд өөрсдийнх нь хүсэлтийг харгалзан Захиргаанаас баталсан хуваарийн дагуу тухайн жилд нь багтаан эдлүүлнэ.

4.9 ҮЭХ-той хамтран бүх ажилтны идэвхтэй амралтыг жилд **1** удаа зохион байгуулна.

4.10 Ажилтны эхнэр нь амаржсан үед ажлын ачааллыг харгалзан ажлын 10 хоног хүртэл цалинтай чөлөө олгоно.

Тав. Хөдөлмөр хамгаалал, хөдөлмөрийн нөхцөл сайжруулах талаар

5.1 Ажил олгогч хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн шаардлагыг хангах, хөдөлмөр хамгааллыг сайжруулах ажил, хөтөлбөрийг ҮЭХ-той зөвшилцөн гаргаж мөрдүүлнэ.

5.2 Ажил олгогч ажилтны хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн шаардлагыг бүрэн хангах, аюулгүй ажиллагааны дүрэм, зааварчилгааг тогтмол өгч, ажиллуулах ба тухай бүрт гарын үсгээр баталгаажуулж байна.

5.3 Ажил олгогч нийт ажлын байрны **стандарт** нөхцөлийн үнэлгээг мэргэжлийн хяналтын байгууллагаар гүйцэтгүүлж зохих шаардлагыг биелүүлж ажиллана.

5.4 Хөдөлмөрийн хуулийн тухай 88 дугаар зүйлийн 88.3 дахь хэсэгт зааснаар ажилтны эрүүл мэндийг урьдчилан сэргийлэх үзлэг хийлгэхэд шаардагдах зардлыг Ажил олгогч хариуцна. *(жилд 1 удаа)*

5.5 Ажил олгогч нь хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлд ажилладаг ажилтанд дараах хөнгөлөлт эдлүүлнэ. Үүнд:

5.6.1 ажлын өдрийг богиносгох,

5.6.2 хор саармагжуулах бодис, хүнсний бүтээгдэхүүн олгох болон зах зээлийн үнээр мөнгийг нь бодож олгох,

5.6.3 ажлын зориулалтын хувцас, багаж хэрэгслээр хангах,

5.6.4 эрүүлжүүлэх, витаминжуулах ажлыг зохион байгуулах.

5.6 Ажил олгогч нь ажилтны хөдөлмөрийн нөхцөл, ажил үүргийн онцлогт тохируулан аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслээр хангах бөгөөд тэдгээрийг цэвэрлэж ариутгах нөхцөлийг бий болгоно. Ажилтанд олгох тусгай ажлын хувцас, хамгаалах хэрэгслийн төрөл,

жагсаалт, эдгээрийн хугацаа, норм, тэдгээрийг цэвэрлэх, ариутгах, засварлах, хугацаа хуваарийг энэхүү гэрээний хавсралтаар батална.

5.7 Ажилтны нөхөн төлбөрийг хуульд зааснаар олгоно.

5.8 Ажилтныг ажлаас халах, чөлөөлөх үед ҮЭХ-нд мэдэгдэх ба Захирлын зөвлөлөөр хэлэлцэхдээ ҮЭХ-ны төлөөллийг байлцуулж, ажилтныг өмгөөлөх, түүнтэй дүйцэхүйц байдлаар хөдөлмөрлөх эрхийг нь хамгаалах бололцоогоор хангана.

5.9 Ажил олгогч нь байгууллагын үйл ажиллагаа болон төлөвлөгөө, төсвийн хөрөнгийн зарцуулалтын асуудлаар хагас жилд 1 удаа мэдээлэл өгөх бөгөөд Үйлдвэрчний эвлэлийн хороо нь мэдээллийн нууцыг хадгалах үүрэг хүлээнэ.

5.10 Байгууллагын жилийн төсөв батлагдах үед Ажилтны цалин хөлс, нийгмийн асуудалд дэмжлэг үзүүлэхтэй холбоотой асуудлаар театрын дэргэдэх Үйлдвэрчний эвлэлийн хорооны төлөөллийг оролцуулан, төсвийн төсөлд санал өгөх оролцоог хангана.

5.11 Ажил олгогч жил бүрийн төсөвтөө "Хөдөлмөрийн аюулгүй байдал, Эрүүл ахуйн тухай хууль"-ийн 26 дугаар зүйлийн 26.2 дахь хэсэгт заасан төсвийн байгууллагын үйл ажиллагааны зардлын 0,5 хувьтай тэнцэх зардлыг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн болон үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зарцуулна.

5.12 Улсын Драмын Эрдмийн Театрын Захиргаа нь Хөдөлмөрийн эрхийн маргаан таслах комиссыг Засгийн газрын 2022 оны 153 тоот тогтоолоор баталсан "Хөдөлмөрийн эрхийн маргаан таслах комиссийн дүрэм"-ийн дагуу ажиллуулна.

5.13 Улсын Драмын Эрдмийн Театрын Захирлын 2025 оны 10 сарын 17-ны өдрийн А/60 тоот тушаалаар баталсан Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөл нь Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийг байгууллагад хангаж ажиллах бөгөөд төлөвлөгөө, төсвийг боловсруулж ажиллана.

5.14 Улсын Драмын Эрдмийн Театрын Захирлын 2025 оны 11 сарын 03-ны өдрийн А/68 тоот тушаалаар баталсан Үйлдэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх орон тооны бус байнгын комисс нь Засгийн газрын 2015 оны 269 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан "Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх дүрэм"-д заасны дагуу ажиллана.

5.15 Үйлдвэрчний эвлэлийн хорооны төлөөллийг дараах комисс, зөвлөлийн үйл ажиллагаанд хамтран зөвшилцөж ажиллуулна. Үүнд:

5.15.1 Хөдөлмөрийн эрхийн маргаан таслах комисс,

5.15.2 Үйлдэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх орон тооны бус байнгын комисс,

5.15.3 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөл.

Зургаа. Ажилтны мэргэжил, мэдлэгийг дээшлүүлэх талаар

6.1 Уран бүтээлчид, ажилтнуудын мэргэжил ур чадвар, хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх сургалт, семинарыг ажлын байранд ҮЭХ-той хамтран жилд 1-2 удаа зохион байгуулах ба сургалтын зардлын 50 хүртэлх хувийг ҮЭХороо хариуцна.

6.2 Ажлын байранд түр сургалтад хичээл заасан гадны багш нарт цагийн хөлсийг тухайн цаг үеийн зах зээлийн ханшаар *(өөрийн байгууллагад ажиллаж буй мэргэжилтэн эсвэл магистр зэрэгтэй багш хичээл заавал 1 цагийн буюу 60 минут нь 50,000-100,000 төгрөгөөс доошгүй байна)* бодож хөлс олгоно.

6.3 Ажилтан албан хаагчдад мэргэжлийн чиглэлийн сургалт явуулан, түвшин тогтоох зорилгоор мэргэжил, ур чадварын түвшин тогтоох шалгалтыг 3 жилд 1 удаа явуулна. Ажилтныг мэргэжил, ур чадварын түвшин тогтоох шалгалтад хамруулахдаа тухайн ажилтанд **2 сараас доошгүй** хугацааны өмнө мэдэгдэх ба болзол, журмыг **1 сараас доошгүй** хугацаанд урьдчилан танилцуулсан байна.

6.4 Ажилтан дотооддоо мэргэжлийн зэргээ ахиулах, мэргэжлийн сургалтад хамрагдан суралцахаар бичгээр хүсэлт гаргасан тохиолдолд байгууллагын санхүүгийн боломж, орлогын төлөвлөгөөний биелэлт, уг ажилтны цаашид тогтвор суурьшилтай ажиллах, байгууллагын хөгжилд нөлөөлөх эсэхийг нь харгалзан Захиргааны зөвлөлийн шийдвэрийг үндэслэн, нэг удаагийн сургалтын төлбөрийн **50 хүртэлх** хувийн дэмжлэг үзүүлнэ.

6.5 Жилийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу олон улсын хурал, зөвөлгөөн, сургалт, гадаадын фестивальд оролцох болсон тохиолдолд түүний хөдөлмөрийн амжилт, идэвх оролцоо, хэлтэс, албад, хамт олны саналыг үндэслэн замын зардлын тодорхой хувийн дэмжлэг үзүүлнэ.

6.6 Ажилтны зүгээс мэргэжил эзэмших, олгох сургалт, ахисан түвшний сургалтад хамрагдах хүсэлтийг дэмжин, анги дэвших болон сургууль төгсөх үед ажлын 7-14 хоногийн цалинтай чөлөө олгоно.

Долоо. Нийгэм, ахуйн хөнгөлтийн талаар

7.1 Ажилтны нийгмийн хамгаалал, нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд жил бүр **шаардлагатай** хөрөнгийг төсөвлөн зарцуулна.

7.2 Театрын ажилтан болон театрын үйл ажиллагаатай нягт холбоотой ажилладаг төрийн захиргааны болон салбарын бусад байгууллага, ажилтнаас хөдөлмөрийн өндөр амжилт гаргасан, төрийн дээд цол, одон тэмдэг хүртсэн болон насны ой, уран бүтээлийн цэнгүүн, тэмдэглэлт үйл явдлыг тохиолдуулан хүндэтгэл үзүүлэн 500,000 төгрөгөөс доошгүй шагнал, урамшуулал, бэлэг дурсгалын зүйлийг олгоно.

7.3 Ажил олгогч нь ажлын завсарлага, ажлын цагийн графиктай уялдуулан хоолны газрыг тогтмол ажиллуулах үүрэг хүлээх ба хоолны меню, үнэ тарифт хяналт

тавьж, байгууллагын ажилтанд хөнгөлөлттэй үнээр үйлчлэх нөхцөлийг бүрдүүлнэ.

7.4 Гэр хороололд амьдардаг ажилтанд жил бүр 1-2 тонн нүүрсний үнийг байгууллагаас гаргаж үнэгүй олгоно. Ингэхдээ хэлтэс, албадаас гаргасан саналыг үндэслэн энэхүү хөнгөлөлтөд хамрагдах ажилтны нэрсийг гаргана.

7.5 Ажилтан, албан хаагчдад нийтийн тээврийн унааны зардлыг өдрийн 1,000 төгрөгөөр, өдрийн хоолны нэмэгдэл 19,000 төгрөгөөр тооцож, сар бүр цалин дээр бодож олгох ба тухайн цаг үеийн үнийн инфляцтай уялдуулан өдрийн хоол, унааны мөнгийг нэмэгдүүлэх талаар театрын захиргаатай харилцан зөвшилцсөний үндсэн дээр шийдвэрлэнэ.

7.6 Ажил мэргэжлээс шалтгаалан өвдсөн нь нотлогдсон зайлшгүй тусламж үзүүлэх шаардлагатай гэж үзсэн ажилтныг дотоодын рашаан сувилалд явж эмчлүүлэх зардлын 50 хувийг хоёр жилд нэг удаа ажил олгогч төлнө.

7.7 Жирэмсний болон амаржсаны амралттай ажилтанд Хөдөлмөрийн тухай хууль, Ниймгийн даатгалын шимтгэлийн тухай хуульд зааснаар тэтгэмж олгоно.

7.8 Ажилтнуудад дараах тохиолдолд буцалтгүй тусламж олгоно. Үүнд:

7.8.1 Өөрийн эцэг эх, эхнэр нөхөр, үр хүүхэд нь нас барвал **1,000,000 төгрөгнөөс доошгүй**, өвөө эмээ, төрсөн ах дүүс нас барвал **500,000 төгрөгнөөс доошгүй.**

7.8.2 Ажилтан өөрөө нас барвал хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2-5 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөг,

7.8.3 Театрын ахмад ажилтан, тэдний гэр бүл, театрын хөгжилд бодитой хувь нэмрээ оруулсан хамтран ажиллаж байсан соёл урлагийн зүтгэлтэн нас барсан тохиолдолд **500,000 төгрөгнөөс доошгүй,**

7.8.4 Ажилтны гэр орон, байгалийн гамшиг, гэнэтийн аюулд нэрвэгдсэн тохиолдолд **1,000,000 төгрөгнөөс доошгүй,**

7.8.5 Шинээр төрсөн хүүхдэд **300,000 төгрөгнөөс доошгүй,**

7.8.6 Ажилтан өөрөө удаан хугацаагаар өвчилсөн, осол гэмтэлд өртсөн, хүнд хагалгаа, нарийн мэргэжлийн өртөг өндөр бүхий шинжилгээ хийлгэх тохиолдолд **1,500,000 төгрөгнөөс доошгүй.**

7.9 Хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу жилд нэг удаа ажилтныг эрүүл мэндийн үзлэгт хамруулна.

7.10 16 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажилтны хүүхдийн хиймэл эрхтэн хийлгэх болон хагалгаанд орсон тохиолдолд **300,000 төгрөгнөөс доошгүй** тусламж олгоно.

7.11 Байгууллагаас тэтгэвэр тогтоолгосон ахмад настнуудыг Сар шинийн баяр, Ахмадын өдрөөр хүлээн авч хүндэтгэл үзүүлэн, нэг хүнд дунджаар **100,000 төгрөгнөөс доошгүй** буцалтгүй тусламж үзүүлнэ.

7.12 Ажил олгогч нь үндсэн гэрээгээр ажиллагсад гэрээт уран бүтээл туурвихаар саналаа өгсөн тохиолдолд Уран сайхны зөвлөлийн шийдвэрийг үндэслэн, театрт ажилтны бодит орлогыг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлж, тайлан тоглолт уран бүтээлийн цэнгүүнээ хийж буй уран бүтээлчдэд үнийн хөнгөлөлт үзүүлнэ.

7.13 Театрын нийгмийн хөгжлийн хөтөлбөрт тусгагдсны дагуу тус театрт олон жил үр бүтээлтэй ажилласан, гэр бүлээрээ ажиллаж буй орон сууцгүй ажилтныг түрээсийн орон сууцны хөтөлбөрт хамруулах, хөнгөлттэй зээл олгох, газар эзэмшүүлэх зэрэг үндсэн хөрөнгөтэй болгоход нь чиглэгдсэн бодит ажлуудыг зохион байгуулахад ҮЭХ-той хамтран ажиллах ба үр дүнг нь тухай бүрт тооцож ажилтанд мэдээлж байна.

7.14 Захиргаа Театрын албан хаагчдаас бэлэн бус хэлбэрээр хандив тусламж хураах, цуглуулах нөхцөлд театрын дэргэдэх ҮЭ-ийн гишүүд бичгээр зөвшөөрсөн, эс зөвшөөрснийг баримтжуулан ажил болгоно.

Найм. Үйлдвэрчний эвлэлийн хорооны үйл ажиллагаагаа явуулах нөхцөл бололцоог хангах талаар ажил олгогчийн үүрэг

8.1 Ажил олгогч ҮЭХ-г үйл ажиллагаагаа явуулахад шаардлагатай өрөө тасалгаа, хэрэглэл, харилцах утас, мэдээллийн самбараар хангахын зэрэгцээ өрөөний халаалт гэрэлтүүлэг, цэвэрлэгээний зардлыг хариуцна.

8.2 ҮЭХ-ы гишүүд болон ажилтны хурал хийх байрыг ажил олгогч гаргаж өгнө.

8.3 Захиргаа нь ҮЭХ-нд хамтын гэрээний төсөл боловсруулах, хэлэлцээ хийх болон бусад үйл ажиллагаа явуулахад шаардлагатай санхүү, эдийн засгийн холбогдолтой мэдээ тайлан шаардлагатай мэдээллийг гаргаж өгөх үүрэг хүлээнэ.

8.4 Үндсэн ажлаасаа чөлөөлөгдөөгүй ҮЭХ-ы гишүүний ҮЭ-ийн сургалтанд хамрагдах хурал, зөвөлгөөн, семинар, ярилцлагад оролцох үед албан тушаалын хэвээр хадгалж дундаж хөлсийг олгоно.

8.5 Захиргаа ҮЭХ-ийн татварыг бэлэн бус хэлбэрээр хураах ажлыг зохион байгуулж, татварын мөнгийг МААХҮЭХ-ны Голомт банкны **MN 440034341303487530** тоот дансанд сар бүрийн 25-ны дотор шилжүүлнэ. *(Татвараа бэлэн бусаар хураалгахыг ҮЭ-ийн гишүүд бичгээр зөвшөөрсөн байна.)*

8.6 ҮЭ-ийн гишүүдийн хөдөлмөрлөх эрх түүнтэй холбогдсон хууль ёсны ашиг сонирхлыг хөндөх аливаа шийдвэрийг гаргахдаа 2 долоо хоногоос доошгүй хугацааны өмнө ҮЭ-ийн хороонд танилцуулж, саналыг тусгах ба асуудлыг хэлэлцэх үед биечлэн ҮЭХ-ны төлөөллийг байлцуулна. *(Хөдөлмөрийн болон, Үр дүнгийн гэрээг байгуулах, дүгнэх, ажил өөрчлөх, ажлаас халах, цалин хөлс тогтоох, шагнал урамшуулал олгох, нийгмийн асуудлыг шийдвэрлэх гэх. мэт)*

Ес. Үйлдвэрчний эвлэлийн хорооны хүлээх үүрэг

9.1 Ажилтнуудын хөдөлмөрлөх эрх, хууль ёсны ашиг сонирхолтой холбогдох асуудлаар хуулийн хүрээнд хамтын үйл ажиллагааг зохион байгуулж, ажилтны эрх ашгийг нь хамгаалж ажиллана.

9.2 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулахад анхаарч байгууллагатай хамтарч ажиллана.

9.3 ҮЭХорооны гишүүдийн хууль эрх зүй, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны болон ур чадвар, мэдлэг мэргэжлээ дээшлүүлэх сургалтад ажилтнуудыг хамруулна.

9.4 Хамтын гэрээний төслийг боловсруулахад гишүүдийн санал, хүсэлтийг авч тусгах, гэрээний ач холбогдлыг сурталчлах, хамтарсан сургалт явуулж ажиллана.

9.5 Ажилтны эрүүл мэнд, чөлөөт цаг, аялал жуулчлал, идэвхтэй амралт, олон нийтийн арга хэмжээ, соёл, урлаг спортын тэмцээн уралдаанд зориулж зарцуулах мөнгөн дүнг холбогдох журмын дагуу зарцуулна.

9.6 Нийт гишүүдэд хагас жил тутамд ажлын тайлан гаргаж танилцуулна.

Арав. Хамтын гэрээний хугацаа, түүний биелэлтэд хяналт тавих, түүнд нэмэлт өөрчлөлт оруулах талаар

10.1 Хамтын гэрээ нь хэлэлцэн тохирч, Талууд гарын үсэг зурж, харьяа нутаг дэвсгэрийн хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн байгууллагад бүртгүүлснээр хүчин төгөлдөр болох бөгөөд 3 жилийн хугацаанд мөрдөгдөнө.

10.2 Хамтын гэрээг 3 хувь үйлдэж, батална.

10.3 Талууд Хамтын гэрээний биелэлтийн талаарх мэдээллийг тогтмол солилцох үүрэг хүлээнэ.

10.4 Хамтын хэлэлцээ хийхтэй холбогдсон зардал болон талууд урьдчилан тохиролцож, урьж оруулсан мэргэжилтэнд олгох зардлыг тогтоох журмыг хамтран баталж мөрдүүлнэ.

10.5 Энэхүү гэрээний хавсралт бүр дор дурдсан баримт бичгийг ажил олгогч, ҮЭХ-той зөвшилцсөнөөр баталж мөрдүүлнэ. Үүнд:

10.5.1 Хөдөлмөрийн дотоод журам,

10.5.2 Ажил, албан тушаалын хавсралт,

10.5.3 Албан тушаалын тодорхойлолт, албан тушаалын лавлах,

10.5.4 Хөдөлмөрийн норм, норматив,

10.5.5 Ажилтанд олгох нэмэгдлийн төрөл, олгох нөхцөл,

10.5.6 Шагнал урамшуулал олгох журам,

10.5.7 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн шаардлагыг хангах, хөдөлмөр хамгааллыг сайжруулах арга хэмжээний хөтөлбөр,

10.5.8 Хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлд ажилладаг ажилтанд олгох хор, саармагжуулах бодис, хоол хүнсний бүтээгдэхүүний жагсаалт түүнд хамрагдах ажил мэргэжлийн жагсаалт.

10.6 Хамтын гэрээгээр тохиролцсон асуудлыг биелүүлж байгаа нөхцөлд ажил хаялт зохион байгуулахгүй байх нөхцөлийг ҮЭХороо хүлээнэ.

10.7 Театрын дэргэдэх Үйлдвэрчний эвлэлийн хорооны удирдлага өөрчлөгдөх эсхүл бүрэлдэхүүн шинэчлэгдэхэд энэхүү Гэрээ дуусгавар болох үндэслэл болохгүй бөгөөд тэдгээрийн эрх, үүргийг залгамжлагчид уг Гэрээний хэрэгжилтийг ханган ажиллах үүрэг хүлээнэ.

10.8 Энэхүү гэрээг хэрэгжүүлэх явцад Талуудын хооронд үүссэн маргааныг хамтран хэлэлцэн тохирох бөгөөд эс зөвшөөрвөл холбогдох хууль, тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

АЖИЛ ОЛГОГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

Улсын Драмын Эрдмийн Театрын захирал

1. ...../Н.Наранбаатар/

Уран сайхны удирдагч:

2. ...../Б.Хишигзаяа/

Захиргаа, удирдлагын хэлтсийн дарга

3. ...../С.Энхболд /

Ерөнхий нягтлан бодогч

4. ...../С.Саранчимэг/

Хүний нөөцийн менежер

5. ...../М.Гоомарал/

ҮЙЛДВЭРЧНИЙ ЭВЛЭЛИЙН ХОРООГ ТӨЛӨӨЛЖ:

Үйлдвэрчний хорооны дарга

1. ...../Г.Амгаланбаатар/

Тэргүүлэгч гишүүд:

Жүжигчин

2. ...../М.Тогтохжаргал/

Жүжигчин

3. ...../Ц.Жаргалсайхан/

Цахилгааны инженер, ХАБЭА

4. ...../Э.Даваасүрэн /

Эмэгтэй хувцасны эрхлэгч

5. ...../Н.Нямдарь/

2026 оны 04 сарын 20

БҮРТГЭВ № 05

НИЙСЛЭЛИЙН СУХБААТАР ДҮҮРГИЙН ХЭДЭЛМОР, ХАЛАМЖ[illegible] ҮЙЛЧИЛГЭЭНИЙ [illegible]

2026. оны 05-р [illegible] 22